

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батсанаа	Дугаар	L258
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баян-өнжүүл сум
Төрсөн газар	Баян-Өнжүүл сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Далай ээжийн жас, Гүенгийн жас, Бараатын жас, Цахиуртын жас	Сүм хийдийн дугаар	ТӨБӨ 012, ТӨБӨ 013, ТӨБӨ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар едөр	2007 оны 8-рсарын 17	Ярилцлага авсан хүн	Жужа

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Далай ээжийн жас

Гүмэнгийн жас, Цахиуртын жас, Бараатын жас

Батсанаа: Далай ээжийн жас Төв аймгийн Баянбараат сумын нэг, хоёрдугаар багийн нутагт байдаг жас.100 гаруй лам нар шавилж сууж байсан. Гомбо сахиус гол шүтээн нь байсан. Өндөр гэгээн өөрөө Далай ээж гэж нэрийг өгсөн. Сахиусыг нь аравнайж өөрөө өгсөн. Тэр үед унзад лам нь Цэндориг гэж хүн байсан. Тэгээд ганцхан модон дугантай, чулуун шалтай. Чулуун шалыг нь наян км газраас үхэр тэргээр зөөж авчирч шаллаж байсан. Далай ээжийн жас, Цахиуртын жас хоёрыг хоёуланг нь Өндөр гэгээн нэр хайрласан. Манай Далай ээжийг Далай ээж, Цахиуртыг Цахиурт гэж.

Жужа: Далай ээжийн жасын лам нар аль овоог тахидаг байсан бэ?

Батсанаа: Эрдэнэ овоог тахидаг байсан.

Жужа: Жасын аль талд?

Батсанаа: Жасын хойд талд.

Жужа: Ямар нэгэн ус худаг байна уу?

Батсанаа: Жасын Баянхошуу гэж яг тэр жасны юундаа хэрэглэж байсан худаг бий. Дэргэд нь , зүүн хойд талд нь очихлээрээ мэднэ дээ.Тэр жасын одоо тэр жасын бүрхны алтан мөнгөн хэрэглэлүүд бүрхны тэр алтан хэрэглэлүүд бүгдийг нь тэр шатаасан газраа байгаа. Тэрнийг үзүүлнэ ээ, та нарт. Заагаад өгнө.

Жужа: Хэдэн онд хаагдсан бэ?

Батсанаа: Өө тэр засаг мандах үеэр л хаагдсан юм даа. Тэрнийг би сайн мэдэхгүй. Анхны энэ шажин дэлгэрэхэд чинь хэдэн онд билээ, ерэн онд уу. 57 жил болоод нээлээ гэж байсан юм даа. Тэгэхлээр чинь 57 жил гэдэг чинь гучин хэдэн онд л юм даа, бүгд дээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хуучин засаг захиргааны хуваарийн дагуу ямар хошуу байсан бэ?

Батсанаа: Дайчин бэйсийн хошуу.

Жужа: Та энэ жасын тухай хэнээс сурсан бэ?

Батсанаа: Би өөрөө энэ нутгийн хүн, тэгээд дээрээс нь хөгшчүүлээсээ сонссон. Яг одоо тэр энд нь ийм юм байсан, энд нь ийм юмыг нь шатаасан, ийм дуган байсан гээд би бүгдийг нь хэлээд өгнө, очоод. Цаанаа тэр гүнэм жас дээр бас би мэднэ. Энэ хоёрыг бол бараатуулдаг нь тэр.

Жужа: Тэнд сууж байсан лам нарыг нэрлэнэ үү?

Батсанаа: За одоо би тэр үнзад ламыг юу яалаа. Тэгээд зөндөө өвгөн настай лам нар байсан л даа. Оргодол гэлэн ч гэж байлаа. Сүүлдээ татагдаж явж байгаад ирсэн дээ, Дэмбээ гэж хүн байлаа, Сүхбазар гэж хүн байлаа, Цэндориг үнзад лам нь байсан шүү дээ. Тэгээд бурхан болсон доо.

Жужа: Одоо нэг ч байхгүй?

Батсанаа: Тэр үеийн лам нараас одоо байгаа хүн нэг ч байхгүй.

Жужа: Сумын төвөөс хэд орчим км вэ?

Батсанаа: Ная орчим л байх. Бараатын жас ч ялгаагүй, хоёулаа бараг зэрэгцээ шахуу байгаа.

Жужа: Бараатын жасын тухай та юу мэдэх вэ?

Батсанаа: Бараатын жасын тухай би их сүртэй мэдэхгүй. Ноднин харин тэрэн дээр суварга бүтээсэн. Сайхан шинэ суварга бүтээгээд байж байгаа. Бараат сумын 7-р багийн нутагт шүү дээ. Манай Далай Ээж бол Баянбараат сумын 2-р багийн нутаг.

Жужа: Хэдэн лам байсан бэ?

Батсанаа: Манай Далай жас 100 гаруй ламтай байсан юм гэнэ лээ дээ. Бараатынх 70 гаруй ламтай байсан гэж номон дээр л харагддаг байсан.

Жужа: Хэдэн дуган байсан бэ?

Батсанаа: Ерөөсөө нэг нэг л дуган байсан. Би хоёр дуганыг нь л нүдээрээ үзсэн. Тэр гүмэнгийн, Далай ээжийн дуганыг л мэднэ.

Жужа: Тэнд ямар ямар овоо байсан бэ мэдэх үү, Бараат дээр?

Батсанаа: Тэр Цэрэнпунцаг гээд ярьж байсан даа. Тэр хүн бол Бараат дээр байсан. Данзан гэж хүн байсан байх. Данзан гэлэн гуай гэж, за тэгээд тэр өвгөн улсуудыг тэр болгон би нэрлэж мэдэхгүй байна.

Жужа: Бараатын жас аль овоог тахидаг байсан бэ?

Батсанаа: Бараатын уул.

Жужа: Жасаас?

Батсанаа: Жасаас энүүхэнд, дэргэд нь баруун хойно нь юм даа.

Жужа: Худаг ус?

Батсанаа: Бараатын шанд гэж ил ус бий. Яг тэр суварганыхаа тэнд байгаа.

Жужа: Ямар сахиустай байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батсанаа: Жамсран сахиустай байсан юм.

Жужа: Тэр бас Дайчин бэйсийн хошуу?

Батсанаа: Ялгаагүй, бүгд Дайчин бэйсийн хошуу. Энэ Шинэ ус, энд байж байгаа жас хоёр чинь л Дайчин бэйсийн хошуундаа орж байгаа юм уу, үгүй юм уу мэдэхгүй. Энэ Бараат, Далай ээж, Гүмэн эд нар чинь бүгд Дайчин бэйсийн хошуу.

Жужа: Гүмэнгийн жасын талаар?

Батсанаа: Гүмэнгийн жас гэдэг чинь энүүхэн өмнө ойр байгаа. Бэрхийн тахилга гэж том уулын чинь ард байдаг юм. Нэг л дугантай, тэр Гүмэнгийн ус гэж тэр Гүмэн нэрээр нэрлэсэн. Жижигхэн жас байсан, сахиус нь Намсрай. Шинэ шавийнх чинь Лхам гэж байсан юм. Цөөхөн хүн байсан юм, 40, 50-иад хурлын лам л байсан юм гэнэ лээ. Цагаан сараар хотод хурал хүрж байгаад лам нар нь цагаан сар болохоор чөлөө мөлөө өгдөг юм уу, эндээ ирж хурдаг байсан юм гэдэг. Тэрнээс жинхэнэ цуглаад ирээд байсан улсууд цөөхөн, 30-50-иад улсууд байсан юм уу.

Жужа: Ямар овоо тахидаг байсан юм бэ?

Батсанаа: Бэрх гэж овоо.

Жужа: Худаг ус байсан уу?

Батсанаа: Гүмэн гэж нэртэй худаг жасынхаа яг дэргэд нь байгаа.

Жужа: Аль талд нь, баруун талд уу, зүүн талд уу?

Батсанаа: Зүүн талд нь.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Батсанаа: Манай Далай ээж эргэдэг байсан. Наад энэ дээр би мэдэхгүй, эргэж байгаагүй байлгүй. Далай ээж дээр майдрын овоо гэж байгаа. Би жил болгон очиж сэргээдэг юм, тэрийгээ.

Жужа: Майдар хэзээ эргэдэг байсан бэ?

Батсанаа: Майдар чинь тэр хурлынхаа ямар үед нь эргэдэг байсан юм, одоо манай энэ хийд бол намрын эхэн сарын шинийн гурванд л эргэдэг юм. Тэр эргэдэг эргэдэг өдөр, жас жасаараа байна уу гэхээс тэгж улс даяараа нэг өдөр байгаагүй байх.

Жужа: Хайлан хурдаг байсан уу?

Батсанаа: Хуралгүй яахав, манай Далай ээж, Цахиурт энэ тэрт чинь. Намар л хайлан хүрж байсан юм гэнэ лээ.

Жужа: Цам гардаг байсан уу?

Батсанаа: Майдар эргэхдээ цам гардаг байсан.

Жужа: Хэдэн лам тоглодог байсан бэ?

Батсанаа: Майдарт уу, ерөөсөө тэр майдарт чинь бүх л лам нар явдаг юм ш дээ, миний мэдэхээр. Бүгд л бурхныхаа хэрэглэлийг аваад л ногоон халзан морин тэргэн дээрээ тэгээд л тэр овоон дээрээ очиж ном уншаад л майдар эргэдэг.

Жужа: Ганжуур эргэдэг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батсанаа: Ганжуур эргэнэ.Тэр үед эргэж байсан юм уу, сайн мэдэхгүй. Тэр Төв Гандан дээр л , энэ хөдөөний хийдүүдэд бол. Тэр сүүлийн үед шажин дэлгэрэхэд л хөдөөний хийдүүдэд ганжуур эргэдэг болсноос дээр үед Төв Ганданд л эргэж байсан байх.

Жужа: Халзангийн жасын талаар?

Батсанаа: Халзан Гэлэнгийн жас энүүхэн энэ дэргэд байгаа.

Жужа: Бас ганцхан дугантай байсан уу?

Батсанаа: Тийм байх. Тэрнийг бол би мэдэхгүй.Ер нь бүгд л ганцхан дугантай байсан. Бас энэ Гүмэн шиг цөөхөн лам нар хүрээнээс лам нар ирж хурал хурдаг, Эндээ хурдаг тогтмол ганц хоёр л хүмүүс байсан юм гэнэ лээ. Халзан Гэлэнгийн жасын унзад лам нь улаан малгай Жамц гуай гэж хүн байсан юм гэнэ лээ. Хамба лам нь Өнгөө гэлэн гэж хүн байсан юм гэнэ лээ. Моринд их эртэй хүн байсан гэж ярьдаг юм билээ.

Жужа: Халзан гэлэнгийн жас хэдэн онд байгуулагдсан бэ?

Батсанаа: Тэр мэдэхгүй, их дээр үед л байсан жас юм гэнэ лээ.Энэ жижиг жасууд бол одоо цагаар оюутны амралт шиг хүрээнээс лам нар ирж хурал хурдаг байсан юм гэнэ лээ.

Жужа: Тэгээд энэ жасуудад аль аль хүрээнээс лам нар ирдэг байсан бэ?

Батсанаа: Ганц л Богдын хүрээнээс л ирнэ, өшөө ямар хүрээ байхав.

Жужа: Дэлгэрийн Чойроос?

Батсанаа: Үгүй, манай харин Далай ээжид Дэлгэрийн Чойроос лам нар ирдэг байсан юм. Одоо тэр Заваа Дамдин хамба чинь жинхэнэ манай энэ Далай ээж, Цахиуртын жас хоёрын чинь юу байсан хүн шүү дээ.

Жужа: Энэ Халзан гэлэнгийн жас аль овоо тахидаг байсан бэ?

Батсанаа: Тахиж байсан овоог нь мэдэхгүй юм.

Жужа: Дэргэд нь ямар овоо байна вэ?

Батсанаа: Бага хайрхан, Хоёр булгийн хооронд байгаа юм. Хайрхан булаг, Бага булаг гэж хоёр булгийн хооронд.

Жужа: Гүмэнгийн жас энэ Баянбараатын сумын хэддүгээр багийн нутаг вэ?

Батсанаа: 2, 3-р багийн нутаг.

Жужа: Халзангийнх?

Батсанаа: Халзангийнх 3, 4-р багийн нутаг.

Жужа: Яг ямар нэртэй газар вэ, Халзангийн жас?

Батсанаа: Бага хайрхан. Шинэ ус ч энүүхэнд байгаа юм. Энэ манай Бараат сумын нутаг биш. Өнжүүл сумын нутаг, бас л жалгын жижиг жас байсан юм гэнэ лээ. Харин бариа тавианы үеэр бурхны юмаа энэ тэнд хийчихсэн юм гэнэ лээ:Улсууд тийм ч юм оллоо, ийм ч юм оллоо гээд л тэгж байдаг.Энүүхэнд байдаг юм.

Жужа: Шинэ ус ямар нэртэй газар байсан бэ, уулын нэр?

Батсанаа: Энэ Хойд Өнжүүл гэдэг уулын л урд талд нь байгаа юм. Цээлээс баруун тийшээ жалганд байдаг юм.

Жужа: Ижригийн жас?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батсанаа: Ижригийн жас Баянбараат сумын 5, 6-р багийн нутаг. Бас л 60 гаруй лам нартай хурал байсан юм гэнэ лээ. Ямар сахиустай байсныг нь сайн мэдэхгүй байна. Унзад лам нь Дашням гэж манай Баянбараат сумын дарга байсан хүн дээ. Тэгээд сүүлдээ Төв аймагт Зуунмодод очоод лам болоод тэндээ өнгөрсөн.

Жужа: Ямар овоо тахидаг байсан бэ?

Батсанаа: Тэр хавьд нь ойрхон тахидаг овоо байгаагүй. Мэдэхгүй юм байна.

Жужа: Ямар нэгэн ус худаг бий юу?

Батсанаа: Дэргэд нь нэг махир худаг байдаг юм.

Жужа: Халзангийн жас хэдэн ламтай байсан бэ?

Батсанаа: Харин ирж очдог, цөөхөн лам нартай байсан юм гэнэ лээ. Нэг 4, 5 л лам байнгын сууж байдаг. Тэгээд хүрэнээс цөөхөн лам ирж хурдаг.

Жужа: Шинэ ус?

Батсанаа: Шинэ ус ч тийм байсан юм гэнэ лээ. Би сайн мэдэхгүй. Байгаа газрыг нь л загаад өгч мэднэ.

Жужа: Гүмэнгийн жас хэдэн ламтай байсан бэ?

Батсанаа: Манай энэ хөгшний эцэг нь тэр Гүмэн дээр байсан юм гэнэ лээ. Нэг 40, 50-иад лам байсан гэж ярьдаг юм. Бас хүрэнээс лам нар ирж, зарим үед их олон лам ирж хурал хүрж байсан юм гэнэ лээ. Манай энэ Дайчин бэйсийн хошууны дотор Далай ээж, Цахиурт хоёр л хамгийн том жас байсан юм даа, хөөрхий.

Жужа: Улхын жасын талаар?

Батсанаа: Би ёстой мэдэхгүй байна. Улхын жас дээр очиж үзээгүй. Энүүхэнд Зангийн жас гэж байсан юм аа. Улх гэдгийг чинь мэдэхгүй юм аа. Улх гэдэгт жас гэж байгаа ч гэж мэдээгүй.

Жужа: Ямар жас байсан гэнэ ээ?

Батсанаа: Зангийн жас гэж энүүхэнд байсан юм гэнэ лээ. Би сайн мэдэхгүй, нутгийн улсууд мэдэх байх. Манай Бараатынх биш, Өнжүүлийн нутаг л даа.

Жужа: Баянбараатад өөр жас байгаагүй юу?

Батсанаа: Баянбараатад тэр Ижриг, Бараат, Далай ээж, Гүмэн, Халзан гэлэнгийн жас гэдэг энэ 5 чинь манай Бараатын нутагт байгаа.

Энхбаяр: Баянбараатын сумын төв байна ш дээ, тэрэн дээр жас байсан уу?

Батсанаа: Байгаагүй, яг тэр төв дээр нь байгаагүй. Тэрний өмнөхөн тэр Бараат чинь байсан юм. Тэр Бараат гэдэг уулаар Баянбараат гэж нэрлэсэн байхгүй юу. Бараат гэж том тахилгатай уул өмнө нь бий. Дээрээ суваргатай.

Жужа: Яг энэ хавьд зоч, лүйжин тавьдаг лам нар байсан уу?

Батсанаа: Өө мэдэхгүй, тэр байсан л байсан. Тодорхой мэдэх юм байхгүй.

Жужа: Энэ жасуудаас аль нь суваргатай байсан?

Батсанаа: Аль нь ч суваргагүй. Би харин Далай ээжийн жас дээр, тэр өөрийнхөө жас дээр суварга бүтээлгэх санаатай байгаа юм. Тэр Далай ээжийн тэр хавиар байсан хүмүүс энэ суман дээр нэг суварга байгаа биз, тэрийг чинь босгосон юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хэдэн онд бүтээсэн юм?

Батсанаа: Уржнан 2005 онод хоёр суварга бүтээсэн юм. Нэг нь энэ Их хайрхны тэртээ энүүхэнд суварга бий. Энэ нутгийнхны л хийсэн буян даа.

Жужа: Нөгөө суваргыг хэдэн онд бүтээсэн юм?

Батсанаа: Нэг жил, нэг өдөр зэрэг бариад, суварга бүтээсэн хүн нь зэрэг бариад. Манай энд суваргыг их хурдан барьдаг залуу байдаг юм ш дээ, их уран.

Жужа: Хятад наймаачид байсан уу?

Батсанаа: Наймаачид уу, тэр манай Далай ээжийн жас байсны тэндээс Хамрын наймааныхан гэж нэг дэнж байдаг юм. Тэнд л тийм хятад наймаачид байсан гэж ижий минь ярьдаг юм.Хамрын наймааныхан гэж, тэр газрын нэр нь Дунд баян хошуу гэж. Хотны хонины ноос энэ тэр авч явдаг, хүүхдүүдэд чихэр боов өгдөг тийм байсан юм.

Жужа: Энэ Баянбараатыг яагаад Баянбараат гэж нэрлэсэн юм?

Батсанаа: Тэр уулынхаа нэрээр нэрлэхгүй юу, Бараат гэж. Тэгээд Бараат сүм гэхээр бэлэгшээж Баянбараат сүм гэхгүй юу. Энэ манай өмнө уул чинь Баян уул юм шүү дээ. Тэр урдах тэр энэ шинэ сумын, та нар үзээгүй болохоор мэдэхгүй байх л даа: Энүүхэнд нэг уул байгаа. Тэрнээс цаашаа Бараат гээд тахилгатай уул байгаа. Энэ Баян-Өнжүүл гэдэг нь энэ Баян , тэгээд тэр Өнжүүл уулын нэрээр нэрлэсэн юм гэнэ лээ.

Жужа: Хэдэн онд нэг болсон бэ, энэ хоёр?

Батсанаа: Баян-Өнжүүл үү, 1973 онд.

Жужа: За одоо болсон, баярлалаа.